

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 12-р сарын 02

№ 17/112

Улаанбаатар хот

Энэхүү **Ажил гүйцэтгэх гэрээ** /цаашид “Гэрээ” гэх/-г Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл болон холбогдох зүйл заалтуудыг үндэслэн,

Нэг талаас ЧД 5 хороо Нарны Титэм 2 давхар хаягт байрлах, ЛЭДИ ХХК-ний Харилцан хамааралтай маркетингийн сургалт зөвлөгөөний төв ТББ /цаашид ИМАКО ИНСТИТУТ / цаашид “**гүйцэтгэгч**”, /-г төлөөлж , маркетингийн менежер Б.Итгэлт

Нөгөө талаас Цагдаа Дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв /цаашид “**Захиалагч**”, хамтад нь “**Талууд**” гэх /-г төлөөлж Ахлах нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч М.Мөнх-Эрдэнэ нар нь дараах нөхцлөөр харилцан тохиролцож гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь Захиалагчийн заавар, удирдамжийн дагуу түүнээс өгсөн загвар, өгөгдлийн дагуу гэрээний 3-р зүйлд заагдсан ажлыг гэрээт ажлын хугацаанд чанарын шаардлага хангахуйц түвшинд хийж гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгөх, Захиалагч нь гүйцэтгэгч талд гэрээгээр тохиролцсон ажлын хөлсийг төлөхтэй холбогдон үүсэх талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулна.

1.2. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль, талуудын гэрээг байгуулах болсон үндэслэл, хүсэл зоригийн илэрхийлэл, гэрээний агуулга, Захиалагчийн зааварчилгаа зэргээр тус тус зохицуулна.

1.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар, бодитоор, зохих ёсоор гүйцэтгэх бөгөөд хамтран ажиллах, харилцан туслалцах зарчмыг мөрдлөг болгоно.

1.4. Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн нь энэхүү гэрээнд заасан чанарын шаардлага хангасан, аливаа эрхийн зөрчилгүй, доголдолгүй зүйл байна.

1.5. Ажил гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хийж гүйцэтгэхдээ бусдын хийж гүйцэтгэсэн ажлыг хуулбарлахгүй байх, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан аливаа эрхийг зөрчихгүй байх үүрэг хүлээнэ.

Хоёр. Ажил гүйцэтгэх хугацаа

2.1 Энэхүү гэрээг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаатай байгуулав. Үүнд:

2.2 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас /байгалийн гамшиг, дайн, дайн бүхий байдал, халдварт өвчин, хорио цээр, бослого/ гүйцэтгэх ажлын хугацаа хэтэрсэн тохиолдолд талууд харилцан тохиролцож уг хугацаагаар сунгаж болно.

ТАЛУУДЫН ГАРЫН ҮСЭГ

ТОРИЙН САЛТ
МЭГЭГ АЖИЛ ГЭРЭЭ
(5921,600)

Гурав. Гүйцэтгэх ажил, үйлчилгээ

- 3.1 Гүйцэтгэгч талын гүйцэтгэх ажил нь Захиалагч талын захиалсан сэдвийн дагуу 2 өдрийн интерактив, оролцоонд түшиглэсэн сургалтыг хугацаанд нь зохион байгуулна.
- 3.2 Нийт 3 удаа /6 өдрийн/-гийн сургалтыг цаг тухайд нь чанартай хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Ажлын хөлс, хөлс төлөх нөхцөл

- 4.1 Нэг хүний сургалтын төлбөр 38'400₮/гучин найман мянга дөрвөн зуу/ төгрөг буюу анги дүүргэлтийг алба хаагчийн тоогоор төлбөр тооцоо хийх.
- 4.2 Тухай бүр санхүүтэй тооцоо нийлж сургалтын төлбөрийг олгох
- 4.3 Захиалагч нь гэрээнд гарын үсэг зурснаар ажлын хөлсийг Гүйцэтгэгч талын нэхэмжлэх дээр дурьдсан хугацаанд, нэхэмжлэх дээрх дансаар шилжүүлнэ.

Тав. Захиалагчийн эрх, үүрэг


- 5.1 Гэрээт ажлын явцтай танилцаж, хяналт тавих,
- 5.2 Гэрээнд заасан үүргийг зохих ёсоор, шударгаар, бодитоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах,
- 5.3 Гүйцэтгэсэн ажлын үр дүн нь чанарын болон эрхийн шаардлага хангахгүй бол Ажил гүйцэтгэгч талд гомдлын шаардлага гаргах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах,
- 5.4 Гүйцэтгэсэн ажлын үр дүн нь чанарын шаардлага хангахгүй бол ажлын хөлсийг гүйцэтгээгүй үүргийн хэмжээгээр бууруулж төлөх, эсхүл төлөхгүй байх эрхтэйн зэрэгцээ өөрийн зардлаар гэрээт ажлыг шинээр гүйцэтгэхийг Ажил гүйцэтгэгчээс шаардах,
- 5.5 Гүйцэтгэгч талын ажлын дүгнэлтийг захиалагч тал гаргаж өгөх,
- 5.6 Гэрээнд заасан хугацаанд зохих журмын дагуу гэрээний хөлсийг төлөх,
- 5.7 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Зургаа. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 6.1 Гэрээнд заасан хөлс төлөхийг Захиалагчаас шаардах.
- 6.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүн нь чанарын шаардлага хангаагүй бол өөрийн зардлаар дахин хийж гүйцэтгэх, эсвэл Захиалагч талд учирсан хохирлыг нөхөн төлөх,
- 6.3 Гэрээт ажлын чанар, бусад зүйлтэй холбоотой аливаа мэдээллийг Захиалагчид мэдээлж байна.
- 6.4 Гэрээт ажлыг чанарын болон эрхийн шаардлага хангах түвшинд хийж гүйцэтгээгүй тохиолдолд энэхүү гэрээний 6-р зүйлд заасан Захиалагчийн эрхийг биелүүлнэ.
- 6.5 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Долоо. Хариуцлага

- 7.1 Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй буюу хугацаа хэтрүүлсэн бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10-20 хувийн торгууль Захиалагчид төлнө.
- 7.2 Ажил гүйцэтгэгч гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу ажлын үр дүнд чанарын болон эрхийн зөрчил гаргасан бол Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзах, эсвэл гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж, зардлыг Ажил гүйцэтгэгчээс нэхэмжлэх эрхтэй.
- 7.3 Захиалагч нь гэрээнд зааснаар ажлын хөлсийг төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний нийт үнийн дүнгээс 0.3 хувийн алдангийг Гүйцэтгэгчид төлнө.



ТАЛУУДЫН ГАРЫН ҮСЭГ




Найм. Бусад зүйл

- 8.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно
- 8.2 Гэрээг 2 /хоёр/ хувь үйлдэх ба талууд тус бүр 1 /нэг/ хувийг хадгална.
- 8.3 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд талууд бичгээр үйлдэж, гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 8.4 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

Гэрээ байгуулсан:

Захиалагчийг төлөөлж:

ИМАКО ИНСТИТУТЫН
МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР



БУЯНТОГТОХ ОВОГТОЙ ИТГЭЛТ
Утас: 91111262
Хаяг:
Монгол улс, Улаанбаатар хот,
ЧД 5 Хороо Нарны титэм 2 давхар
Утас: 99043671 11-317989

Гүйцэтгэгчийг төлөөлж:

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
СУРГАЛТЫН НЭГДСЭН ТӨВ
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ



М.МӨНХ-ЭРДЭНЭ
Утас: 70191084
Хаяг: СХБ-ийн 21-р хороо

Утас: 88784884



ТАЛУУДЫН ГАРЫН ҮСЭГ

